



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/80

Улаанбаатар хот

Хүнсний ногоо тариалах иргэдэд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Хүнсний ногооны үр олгоход шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Зарцуулах 703,520 (Долоон зуун гурван мянга таван зуун хорь) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тариалалтад олгох үрийг авч ирэх, тариалан эрхлэгчдэд олгох ажлыг шуурхай зохион байгуулж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон эргэн танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200272

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны..... дугаар сарын.....ны өдрийн
1780..... дугаар захирамжийн хавсралт



ХҮНСНИЙ НОГООНЫ ҮР ИРГЭДЭД ОЛГОХОД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Олгох тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (мян.төг)
1	Шар лууван (Шантенэ 2461)	кг	2	17,010	34,020
2	Шар манжин (Шведская жёлтая)	кг	5	18,550	92,750
3	Хүрэн манжин (Бордо237)	кг	5	17,350	86,750
4	Урт сонгино (Алтай)	кг	2	16,000	32,000
5	Тарвас	кг	0.1	-	8,000
6	Саримс (Цагаан хальст)	кг	50	4,000	200,000
7	Төмс	кг	100	340	34,000
8	Байцаа (Харрикейн)	уут	1	26,000	26,000
9	Хэмх ил талбайд	уут	10	14,000	140,000
10	Шатахуун (A92)	л	20,7	2410	50,000
Нийт дүн					703,520